



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/174

Булган сум

### “Устгал” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 06/05 тоот зөвлөмжийн 1.6, Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн нэр бүхий сумдын газар нутагт зэрлэг байдлаар ургаж байгаа каннабис ургамлыг устгах нэгдсэн арга хэмжээний зардалд 3,298,000 (гурван сая хоёр зуун ерэн найман мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа нэгдсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд хийх, устгалын талаарх дүнг аймгийн Засаг даргад 2024 оны 07 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Ганбаяр)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү арга хэмжээний явцад хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Одхүү)-т даалгасугай.

4. Дээрх нэгдсэн арга хэмжээний үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалт хийх зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010627